60
61

УЛСЫН ДЭЭД ШҮҮХЭД ГОМДОЛ ГАРГАХ НЬ

2026.07.20 Улаанбаатар хот

Гомдол гаргагч:
"Гидродизайн инноваци" ХХК
Регистр: 5822084
Хаяг: Баянзүрх дүүрэг, 26-р хороо,
Хүннүгийн гудамж, Sunrise center, 12
давхар, 1201 тоот

"Монре даатгал" ХХК,-ийн нэхэмжлэлтэй "Гидродизайн инноваци" ХХК болон Б.Алтансүх нарт холбогдох гэм хорын хохиролд 108.640.273 төгрөг гаргуулах тухай хэрэг

Баянзүрх Сүхбаатар Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны тойргийн 2026.03.09-ны өдрийн №191/ШШ2026/03509 дугаар шийдвэр, Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2026 оны 06 сарын 10-ны өдрийн 13/23 магадалаар "Гидродизайн инноваци" ХХК-с 48.888.122 төгрөгийг гаргуулж нэхэмжлэгчид олгохоор шийдвэрлэснийг эс зөвшөөрч энэхүү гомдлыг гаргаж байна.

Анхан шатны болон давж заалдах шатны шүүхүүд хэргийг хянан шийдвэрлэхдээ маргааны үйл баримтыг бүрэн, бодитой тогтоож, түүнд үндэслэл бүхий хууль зүйн дүгнэлт хийгээгүй, хэрэгт авагдсан нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн, бодитой үнэлээгүй, мөн холбогдох хуулийн зохицуулалтыг буруу тайлбарлан хэрэглэсэн гэж үзэж байна. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172 дугаар зүйлийн 172.2.2 дахь заалт заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан бөгөөд уг зөрчил нь шүүхийн шийдвэрт бодитойгоор нөлөөлсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

Үүнд:

1. 2022 оны 10 дугаар сарын 08-ны өдөр хариуцагч Б.Алтансүх нь Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын нутагт 7804 УНН улсын дугаартай "Гидродизайн инноваци" ХХК-ийн өмчлөлийн тээврийн хэрэгслийг жолоодон замын хөдөлгөөнд оролцож байхдаа харанхуй орчинд зам дээр ослын анхааруулах тэмдэггүй зогсолт хийсний улмаас 3144 УАР улсын дугаартай Ford Ranger маркийн машин араас нь мөргөж зам тээврийн осол гарсан. Б.Алтансүхийг Монгол Улсын замын хөдөлгөөний дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.5-д "Ослын зогсолтын тэмдгийг аюул учруулж болзошгүй газраас ойртон ирэх жолооч нарт тухайн саадыг урьдчилан анхааруулах зорилгоор тэдний ирэх зүгт хандуулан, тээврийн хэрэгслээс суурин газарт 15 м-ээс, суурин газрын гаднах замд 30 м-ээс, тууш замд 50 м-ээс багагүй зайд байрлуулна", мөн зүйлийн 9.3-д заасан ослын дохионы гэрлийг "харанхуй үед замын гэрэлтүүлэггүй хэсэгт болон тээврийн хэрэгслийг замаас гаргах боломжгүйн улмаас зорчих хэсэг, хөвөөн дээр зогсоосон тохиолдолд" хэрэглэхээр заасныг тус тус зөрчсөний улмаас зам тээврийн осол болсныг тогтоож 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдөр 0025404 тоот шийтгэлийн хуудсаар Монгол Улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.14 дүгээр хэсгийн 7.14.51-д зааснаар 100.000 төгрөгөөр торгох

шийтгэл оногдуулсан нь үндэслэлгүй осол болсон шалтгаан нөхцөлийг буруу тогтоосны улмаас "Гидродизайн инноваци" ХХК нь Б.Алтансүх нар одоо ийм байдалд ороод байна. Дундговь аймгийн цагдаагийн газраас 2222000224 дугаартай хэрэгт хохирогч Б.Баянбаатар, М.Баяржаргал нарын мэдүүлэгт өөдөөс тод гэрэл гарч ирж зогсоох арга хэмжээ авсан том ачааны машины чиргүүлийг мөргөсөн гэж мэдүүлсэн байна.

2. "МСМ групп" ХХК-ийн 31-44 УАР улсын дугаартай Ford Ranger маркийн тээврийн хэрэгсэл нь ослын улмаас автомашины явах эд анги гэмтэж, бүрэн сүйрсэн гэж дүгнэсэн нь үндэслэлгүй бүрэн сүйрсэн талаар баримт байхгүй.
3. "Гидродизайн инноваци" ХХК нь 78-04 УНН улсын дугаартай HD-450 загварын цагаан өнгийн, Hyundai чирэгчийг "МСМ групп" ХХК-ийн 31-44 УАР улсын дугаартай Ford Ranger маркийн тээврийн хэрэгсэл нь мөргөөгүй харин LA93ACBSD77AR2104 арлын дугаартай 2007 оны улаан өнгийн 2728АР улсын дугаар гэрчилгээтэй Liang Shan маркийн Дабааням овогтой Отгонжаргалын эзэмшлийн чиргүүлийг мөргөсөн талаар гэрчүүдийн мэдүүлэг болон хавтас хэрэгт авагдсан фото зураг, хэргийн газрын зургаар нотлогдсон тул "Гидродизайн инноваци" ХХК нь дээрх хохирлыг хариуцахгүй гэж үзэж байна.
4. "Гидродизайн инноваци" ХХК, Б.Алтансүх нарын хооронд 2022 оны 10 дугаар сарын 01-ны өдөр Г-26/22 дугаартай "Автомашин түрээслэх тухай гэрээ" байгуулагдсан байх бөгөөд уг гэрээгээр "Гидродизайн" ХХК-ийн өмчлөлийн 78-04 УНН улсын дугаартай тээврийн хэрэгслийг 1 сар хүртэл хугацаатай, 2.000.000 төгрөгөөр түрээслүүлсэн бөгөөд Б.Алтансүх нь түрээсийн гэрээний 4.3-д Монгол Улсын замын хөдөлгөөний зөрчсөнөөс гарах үр дагаврыг жолооч өөр хариуцан гэж тохирсон Б.Алтансүх нь Монгол Улсын замын хөдөлгөөний дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.5-д заасан дүрэм зөрчсөнөөс осол болох шалгаан үүссэн тул хохирлыг Б.Алтансүх бүрэн хариуцах ёстой учир нь осол гарах болсон шалтгаан нөхцөл нь зөвхөн жолоочийн замын хөдөлгөөний дүрэм зөрчсөнөөс болсон гэж үзэж байна.

Баянзүрх Сүхбаатар Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүх, Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүх нотлох баримтыг бүрэн дүүрэн үнэлээгүй

Иймд Баянзүрх Сүхбаатар Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны тойргийн 2026.03.09-ны өдрийн №191/ШШ2026/03509 дугаар шийдвэр, Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2026 оны 06 сарын 10 өдрийн 1923 магадлалаар "Гидродизайн инноваци" ХХК-с 48.888.122 төгрөгийг гаргуулах хэсгийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 176 дугаар зүйлийн 176.2.4 шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож өгнө үү.

Гомдол гаргасан
итгэмжлэгдсэн төлөөлөгч: Д. Оюунбаатар / О.Оюунбаатар
Утас: 93010904